



**ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ,
ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН ЯАМ**

ЦАГ ҮЕИЙН МЭДЭЭЛЭЛ

Дугаар 2020/05

**Улаанбаатар хот
2020 он**

ГАРЧИГ

Агуулга	Хуудасны дугаар
1. Аж үйлдвэр	2
2. Мал аж ахуй	4
3. Газар тариалан	6

Үндэсний статистикийн хорооны албан ёсны мэдээг ашиглав.

1.АЖ ҮЙЛДВЭР



Аж үйлдвэрийн салбарын нийт үйлдвэрлэл 2020 оны эхний 5 сард урьдчилсан гүйцэтгэлээр 5.1 их наяд төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 1.9 (27.3%) их наяд төгрөгөөр буурлаа.

Аж үйлдвэрийн бүтээгдэхүүний
нийт үйлдвэрлэл
2020* оны эхний 5 сард



Үүнд уул уурхай, олборлох аж үйлдвэрийн салбарын үйлдвэрлэл 1.8 (34.6%) их наяд төгрөгөөр, боловсруулах аж үйлдвэрийн салбарын үйлдвэрлэл 230.3 (16.1%) тэрбум төгрөгөөр тус тус буурсан нь голлон нөлөөлсөн байна.

Аж үйлдвэрийн салбарын нийт үйлдвэрлэл 2020 оны 5 дугаар сард 1.1 их наяд төгрөг болж, өмнөх сараас 175.7 (19.5%) тэрбум төгрөгөөр өслөө. Үүнд уул уурхай, олборлох аж үйлдвэрийн салбарын үйлдвэрлэл 150.5 (26.2%) тэрбум төгрөгөөр, боловсруулах аж үйлдвэрийн салбарын үйлдвэрлэл 46.6 (21.9%) тэрбум төгрөгөөр өссөн нь голлон нөлөөлсөн байна.

Боловсруулах аж үйлдвэрийн салбарт 2020 оны эхний 5 сард спирт, шохой, шингэн сүү, гурил, ус, ундаа, жүүс зэрэг гол нэр төрлийн бүтээгдэхүүний үйлдвэрлэл 3.8-23.0 хувиар өссөн байна.

Аж үйлдвэрийн салбарын борлуулсан бүтээгдэхүүн 2020 оны эхний 5 сард урьдчилсан гүйцэтгэлээр 5.4 их наяд төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 2.9 (34.9%) их наяд төгрөгөөр буурлаа.

**Боловсруулах аж үйлдвэрийн салбарын бүтээгдэхүүний нийт үйлдвэрлэл,
дэд салбараар**

Дэд салбар	2019		2020*		2020* I-V
	V	I-V	V	I-V	2019 I-V
	сая төгрөг				хувь
Боловсруулах аж үйлдвэр	424 998.4	1 430 484.4	260 143.6	1 200 152.8	83.9
Хүнсний бүтээгдэхүүн, ундаа үйлдвэрлэл	137 520.5	620 849.4	120 997.7	620 379.8	99.9
Мах, загас, жимс, ногоо, өөх, тос боловсруулалт	17 379.1	82 812.4	12 973.9	59 898.6	72.3
Сүү, сүүн бүтээгдэхүүн үйлдвэрлэл	18 885.2	92 496.6	21 753.7	96 505.4	104.3
Үр тарианы гурил, цардуул, малын тэжээл үйлдвэрлэл	15 624.9	81 824.8	19 598.0	94 707.4	115.7
Хүнсний бусад бүтээгдэхүүн үйлдвэрлэл	19 567.3	83 294.7	18 862.7	90 380.5	108.5
Ундааны үйлдвэрлэл /согтууруулах ундаа ороод/	66 064.0	280 420.9	47 809.3	278 887.8	99.5
Тамхины үйлдвэрлэл	3 329.5	8 274.5	4 959.2	7 702.7	93.1
Нэхмэлийн үйлдвэрлэл	153 069.5	337 614.5	51 656.9	160 307.2	47.5
Хувцас үйлдвэрлэл, үслэг арьс боловсруулалт	2 757.4	14 306.2	1 575.4	8 187.2	57.2
Арьс, шир боловсруулах, ширэн эдлэл, гутал үйлдвэрлэл	2 007.1	8 977.6	1 881.4	10 368.3	115.5
Мод, модон эдлэл үйлдвэрлэл	714.3	5 355.6	859.7	5 447.5	101.7
Цаас, цаасан бүтээгдэхүүн үйлдвэрлэл	2 663.0	13 191.3	3 609.3	16 404.1	124.4
Нийтлэх, хэвлэх, дуу бичлэг хийх ажиллагаа	5 657.2	16 153.5	4 513.1	17 042.0	105.5
Кокс, шахмал түлш үйлдвэрлэл	45 869.6	150 146.2	6 783.2	132 734.9	88.4
Химийн бүтээгдэхүүн үйлдвэрлэл	15 477.2	65 973.4	11 361.6	54 111.2	82.0
Резин болон хуванцар бүтээгдэхүүн үйлдвэрлэл	2 997.2	11 382.2	1 449.5	8 795.3	77.3
Төмөрлөг бус эрдэс бодисоор хийсэн эдлэл үйлдвэрлэл	25 798.7	72 111.5	25 874.1	58 231.9	80.8
Төмрийн үйлдвэрлэл	24 589.4	95 061.2	22 968.5	92 277.0	97.1
Машин, тоног төхөөрөмжөөс бусад төмөр эдлэл үйлдвэрлэл	500.0	2 080.6	293.1	1 436.3	69.0
Бичиг хэргийн болон тооцоолох техник үйлдвэрлэл	54.7	775.1	9.7	887.3	114.5
Цахилгаан хэрэгсэл үйлдвэрлэл	73.2	188.5	76.5	351.5	186.5
Эмнэлгийн багаж хэрэгсэл, нарийн хэмжүүр, хараа зүйн хэрэгсэл үйлдвэрлэл	4.3	52.6	4.2	116.5	2.2 ¹
Тээврийн бусад хэрэгсэл	185.2	1 408.1	275.3	1 649.7	117.2
Тавилга үйлдвэрлэл, боловсруулах үйлдвэрийн бусад	1 730.6	6 582.5	995.3	3 722.5	56.6

¹ Дахин их



2.МАЛ АЖ АХУЙ




Улсын хэмжээнд 2019 оны эцэст тоологдсон төллөх

насны нийт 31.0 сая хээлтэгч малын 22.6 сая (72.9%) нь 2020 оны эхний 5 сард төллөсөн байна. Эм хонины 78.4 хувь, эм ямааны 71.6 хувь, үнээний 60.0 хувь, гүүний 48.8 хувь, ингэний 43.6 хувь нь төллөжээ.

Гарсан төлийн 95.9 хувь буюу 21.7 сая төл бойжиж байна. Бойжуулсан төл өмнөх оны мөн үеэс 159.1 (0.7%) мянгаар буурсан байна.



Төл бойжилт, төлийн төрлөөр, хувиар, жил бүрийн эхний 5 сарын байдлаар



Том малын зүй бус хорогдол 2020 оны эхний 5 сард улсын хэмжээнд 1.2 сая болж, өмнөх оны мөн үеэс 590.0 (94.6%) мянгаар нэмэгдсэн байна. Харин 2020 оны 5 дугаар сард 290.6 мянган толгой мал хорогдсон нь эхний 5 сард хорогдсон малын 23.9 хувийг эзэлж байна.


Том малын зүй бус хорогдлыг төрлөөр нь авч үзвэл, хонь 617.6 мянга, ямаа 446.9 мянга, үхэр 87.5 мянга, адуу 61.2 мянган толгой, тэмээ 565 толгой хорогдсон байна. Нийт хорогдсон малын 50.9 хувийг хонь, 36.8 хувийг ямаа эзэлж байна.

Хорогдсон том мал, төрлөөр, жил бүрийн эхний 5 сарын байдлаар

Малын төрөл	Хорогдсон том мал				Оны эхний малд том малын хорогдлын эзлэх хувь			
	2017 I-V	2018 I-V	2019 I-V	2020 I-V	2017 I-V	2018 I-V	2019 I-V	2020 I-V
	мянган толгой				хувь			
Дүн	526.5	1 882.1	623.7	1 213.7	0.86	2.84	0.94	1.71
Адуу	24.9	108.3	31.2	61.2	0.68	2.75	0.79	1.45
Үхэр	56.1	163.6	43.2	87.5	1.38	3.73	0.99	1.84
Тэмээ	0.3	1.2	0.8	0.6	0.06	0.27	0.17	0.12
Хонь	235.1	637.0	259.9	617.6	0.84	2.12	0.85	1.91
Ямаа	210.1	972.1	288.7	446.9	0.82	3.55	1.06	1.53

Хорогдлыг аймгаар нь авч үзэхэд 2020 оны эхний 5 сард Өвөрхангай аймагт 108.3 (8.9%) мянга, Булган аймагт 123.3 (10.2%) мянга, Архангай аймагт 328.1 (27.0%) мянга, Хөвсгөл аймагт 263.5 (21.7%) мянган толгой мал хорогдсон нь нийт хорогдлын 67.8 хувийг эзэлж байна.

Том малын зүй бус хорогдол, аймаг, нийслэлээр, жил бүрийн эхний 5 сарын байдлаар, мянган толгой



Улсын хэмжээнд 2019 оны эцэст тоологдсон 31.0 сая эх малын 278.7 мянга (0.9%) нь 2020 оны эхний 5 сард хорогдсон байна. Булган, Төв, Хөвсгөл, Архангай аймгуудад хээлтэгч мал 24.7-89.1 мянгаар хорогдсон нь нийт хорогдсон хээлтэгчийн 69.2 хувийг эзэлж байна. Харин 32.9 мянган толгой хээлтүүлэгч мал хорогдсоны 14.7 мянган ухна, 14.6 мянган хуц, 2.7 мянган бух, 1.0 мянган азарга, 18 толгой ат байна.

Улсын хэмжээнд 2020 оны эхний 5 сард 35.0 мянган мал өвчнөөр хорогдсон байна. Энэ нь өмнөх оны мөн үеэс 16.1 (85.6%) мянгаар өссөн байна.

Хорогдсон нийт том малын 2.9 хувь нь өвчнөөр, 7.5 хувь нь аюулт үзэгдлээр, 89.6 хувь нь бусад буюу чоно, баавгай, ирвэс зэрэг зэрлэг амьтанд бариулах, мөсөнд цөмрөх, хад асганаас унах, өлдөх, даарах зэрэг шалтгааны улмаас хорогдсон байна.

3.ГАЗАР ТАРИАЛАН



Улсын хэмжээнд 2020 оны 6 дугаар сарын 1-ний байдлаар 375.1 мянган га талбайд тариалалт хийснээс үр тариа 325.3 мянган га-д, техникийн ургамал 21.0 мянган га-д, төмс 13.4 мянган га-д, таримал тэжээлийн ургамал 9.5 мянган га-д, хүнсний ногоо 5.4 мянган га-д, бусад ургамал 0.5 мянган га-д тариалсан байна.

Нийт тариалсан талбай өмнөх оны мөн үеэс 1.9 (0.5%) мянган га-гаар буурсан байна. Ургамлын төрлөөр авч үзвэл, техникийн ургамал 9.3 (30.7%) мянган га, таримал тэжээлийн ургамал 3.4 (26.2%) мянган га-гаар буурч, харин үр тариа 7.2 (2.3%) мянган га, төмс 1.9 (16.7%) мянган га, хүнсний ногоо 1.1 (26.7%) мянган га, бусад ургамал 0.5 (73.9 дахин) мянган га-гаар нэмэгдсэн байна.

Тариалсан талбай, ургамлын төрлөөр, жил бүрийн 6 дугаар сарын 1-ний байдлаар

	2017 VI.1	2018 VI.1	2019 VI.1	2020 VI.1	<u>2020 VI.1</u> <u>2019 VI.1</u>
	мянган га				хувь
Бүгд	447.3	382.1	377.0	375.1	99.5
Үр тариа	357.7	313.0	318.1	325.3	102.3
Бүүдай	342.5	300.9	300.9	315.3	104.8
Төмс	11.9	10.2	11.5	13.4	116.7
хүнсний ногоо	5.1	4.8	4.3	5.4	126.7
Таримал тэжээл	13.5	14.2	12.9	9.5	73.8
Техникийн ургамал	58.6	39.5	30.3	21.0	69.3
Бусад	0.5	0.4	0.0	0.5	73.9 ¹

¹ Дахин их